



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/102

Мөрөн сум

Цэрэг-спортын "Дөл" цогцолбор  
тэмцээнийг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 17 дугаар зүйлийн 17.1.10, Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх, бие бялдрын болон ёс суртахуун, сэтгэл зүйн хүмүүжил олгох, эх орноо батлан хамгаалах бэлтгэл эзэмшүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах Цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг 2022 оны 05 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд Хилийн цэрэг, Зэвсэгт хүчний анги, салбаруудын материаллаг баазыг түшиглэн зохион байгуулж явуулсугай.

2. Аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах Цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээний удирдамжийг нэгдүгээр, зааврыг хоёрдугаар, тэмцээний бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг гуравдугаар, шүүгчдийн нэрсийг дөрөвдүгээр, бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээний удирдамж, зааврыг сумдын Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн, үүрэг чиглэл, зааварчилгааг тогтмол өгч, бэлтгэлийг 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн хангуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб (хурандаа С.Батхуяг)-д даалгасугай.

4. Тэмцээний бэлтгэл болон зохион байгуулах үеийн арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж, батлагдсан удирдамж, заавар, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, хөдөлгөөний үеийн аюулгүй ажиллагааны болон бусад холбогдох дүрэм, журмыг сайтар мөрдүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб (хурандаа С.Батхуяг), сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, ЕБС-ын удирдлага, дасгалжуулагч багш нарт тус тус хариуцуулсугай.

5. Тэмцээнийг зохион байгуулж явуулахад бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Хилийн цэргийн 0257 дугаар анги (хурандаа У.Мөнхбат), онцгой байдлын газар (хурандаа Ё.Пүрэвсүрэн), Зэвсэгт хүчний 321 дүгээр салбар (хошууч Р.Цэрэнтогтох), Биеийн тамир спортын газар (Б.Баярсайхан), Боловсрол, шинжлэх ухааны газар (Ц.Ганзориг), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Ч.Дашбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

6. Тэмцээнийг зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулж, дүнг илтгэхийг Ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб (хурандаа С.Батхуяг)-д даалгасугай.

7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Ш.ИДЭРБАЯСГАЛАН